МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

“КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ НИЙТИЙН ТӨВ” УТҮГ-ЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

“КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ НИЙТИЙН ТӨВ” УТҮГ-ЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025 оны 7 сарын 25-ны өдөр №... Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь “Үндэсний дата төв” УТҮГ-ын төлөвлөгөөнд туссан 8 зорилтын 39 арга хэмжээний 2025 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн 2025 оны жилийн эхний хагас жилийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлсан “Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын үнэлгээний арга зүй болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

“Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 39 арга хэмжээний биелэлтийг 2025 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүнтэй байна.

1. Бүрэн хэрэгжсэн үр дүнтэй буюу 100%-ийн биелэлттэй – 18 арга хэмжээ;
2. Тодорхой үр дүнд хүрсэн буюу 90%-ийн биелэлттэй -3, 70%-ийн биелэлттэй – 6 арга хэмжээ;
3. Боловсруулалтын шатны арга хэмжээ хийгдсэн буюу 50 %-ийн гүйцэтгэлтэй – 3 арга хэмжээ;
4. Эрчимжүүлэх шаардлагатай шатанд байгаа буюу 30% гүйцэтгэлтэй- 4 арга хэмжээ;
5. Үр дүн гараагүй буюу 0%-ийн гүйцэтгэлтэй – 0 арга хэмжээ;
6. Тайлант хугацаа болоогүй -5 арга хэмжээ;

Үнэлгээ хийгдсэн арга хэмжээний дунджаас үзвэл байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 81.1 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна гэж үнэлэгдлээ.

“Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ нь иргэн, хуулийн этгээд, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй хувийн хэвшлийн байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд чиглэсэн кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, кибер халдлага, зөрчилд өртсөн дэд бүтэц, мэдээллийн системийг нөхөн сэргээхэд мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий хүний нөөц, техник, технологийн чадавх, мэдээллийн санг бэхжүүлэх үндсэн зорилгоор ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд тус газрын төлөвлөсөн 8 зорилтын 39 арга хэмжээнээс амжилттай хэрэгжиж буй дараах арга хэмжээнүүд байна гэж үзлээ. Үүнд:

Зорилт 4-ийн арга хэмжээ 4.5-д *"Кибер халдлага, зөрчлийн талаарх дуудлага, мэдээлэл хүлээн авах сувгуудын тасралтгүй ажиллагааг хангах"* төлөвлөгөөний биелэлт амжилттай хэрэгжиж байна. Тодруулбал "Тайлант хугацаанд нийт 998 дуудлага хүлээн авснаас нийтийн төвд хамааралтай 289 дуудлага бүртгэгдэж, 43 байгууллагад хортой программын мэдээлэл хүргэсэн. Мөн www.113.mn цахим хуудасны хэвийн ажиллагааг бүрэн хангаж ажиллаж байна. 113 тусгай дугаарыг автомат хариулагчтай болгох судалгаа хийгдэж, 70001113, 260113 байгууллагын суурин утасруу дуудлага хийхэд IVR автомат хариултаар дамжин байгууллагын дотуур дугаар болох 11132 суурин утсанд дуудлага хүлээн авах болж кибер халдлага, зөрчлийн мэдүүлэг авах сувгийн тоог нэгээр нэмэгдүүлсэн.

-Фэйсбүүк хуудасны чатбот хэсэгт кибер халдлага зөрчлийн талаар мэдээлэл өгөх сувгийн дэлгэрэнгүй мэдээллийг автоматаар хариулж байх тохиргоог нэмсэн.

-Emongolia апп-аар дамжуулан халдлага, зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах тухай саналыг удирдлагад танилцуулсан гэжээ.

Зорилт 4-ийн арга хэмжээ 4.6-д *"Кибер халдлага зөрчлийн бүртгэлийн системийг боловсруулж, системийн сайжруулалт хийх"* төлөвлөлтийн биелэлтийг дараах байдлаар тайлагнасан байна. Үүнд: Техникийн даалгаврыг боловсруулж, системд хөгжүүлэлтийн дараах ажлууд хийгдээд байна.

-Долоо хоногийн тайлан автоматаар гаргах;

-С2 халдлагуудын мэдээллийг API хандалтаар татан авч дэлгэрэнгүй харуулах;

-Тайлан мэдээллийг нэгтгэж график байдлаар харуулах мөн түүн дээр анализ, дүн шинжилгээ хийх;

-Хорт программуудын дотоод тархалтыг автоматаар цуглуулан, мэдээллийн баазад хавсаргах, тайланд нэгтгэн тусгах ажлууд хийгдсэн гэжээ.

Зорилт 7-ын арга хэмжээ 7.3-т "Мэдээллийн аюулгүй байдлын захиалгат сургалтыг зохион байгуулах" төлөвлөлтийн хувьд дараах ажлууд хийгджээ. Үүнд:

Тайланд хугацаанд мэдээллийн аюулгүй байдлын захиалгат сургалтыг нийт 16 удаа зохион байгуулж, сургалтад нийт 790 албан хаагч, 179 оюутан хамрагдсан байна.

1.Мэдээлэл холбооны сүлжээ ХК, Монгол шуудан ХК-ийн захиалгаар 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр мэдээллийн аюулгүй байдлын сургалт, фишинг халдлагын туршилт зохион байгуулсан. Сургалтад танхимаар 72 ажилтан, цахимаар 31 ажилтан, нийт 103 ажилтан хамрагдсан. Мөн тус компанийн захиалгаар мэргэжил танилцуулах сургалтын 11 цагийн хөтөлбөр боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 23, 24-ний өдөр нийт 33 сурагч хамрагдсан.

2.Грандмед эмнэлгийн захиалгаар 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр мэдээллийн аюулгүй байдлын сургалт, фишинг халдлагын туршилт зохион байгуулсан. Сургалтад нийт 53 ажилтан хамрагдсан.

3.Хурдан клубийн сурагчдад зориулсан мэдээллийн аюулгүй байдлын сургалтад 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр 42 сурагч, 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 40 сурагч хамрагдсан.

4. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон Хөдөө, аж ахуйн их сургуулийн ХШУС-ын хүсэлтээр 2025 оны 03 дугаар сарын 20, 21-ний өдөр Кибер аюулгүй байдлын мэргэжлийг сурталчлах, Хортой код, Цахим хуудасны аюулгүй байдал, Сүлжээний аюулгүй байдал сэдвүүдийн хүрээнд сургалт зохион байгуулж, нийт 46 оюутан хамрагдсан.

5.Шинжлэх Ухаан технологийн их сургуулийн Коосэн технологийн коллежийн хүсэлтээр нийт 55 оюутанд 2025.03.31 өдөр Мэдээллийн аюулгүй байдлын сургалт зохион байгуулсан.

6. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын Дархан-Уул аймаг дахь салбарын хүсэлтээр 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр "Цахимд зөв байя" аяны хөтөлбөрийн сургалтыг цахимаар зохион байгуулсан.

7.Онцгой байдлын ерөнхий газрын хүсэлтээр 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Dark web, Web security сэдвээр сургалт орсон. Сургалтад нийт 10 албан хаагч хамрагдсан.

8.Зэвсэгт хүчний жанжин штабын хүсэлтээр 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Dark web, Web security сэдвээр сургалт орсон. Сургалтад нийт 40 албан хаагч хамрагдсан.

9.Үндэсний статистикийн хорооны мэргэжилтнүүдэд 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр 1.5 цагийн хугацаатай сургалтыг зохион байгуулсан. Сургалтад танхимаар 25 албан хаагч, цахимаар 130 албан хаагч оролцсон.

10.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Нэгдсэн Үндэсний Байгууллага зэрэг байгууллагын хүсэлтээр эмнэлгийн албан хаагчдад 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр мэдээллийн аюулгүй байдлын сургалт, фишинг халдлагын туршилт зохион байгуулсан. Нийт 75 албан хаагчид сургалтад хамрагдсан. Фишинг халдлагын туршилтад нийт 26 ажилтнаас 10 ажилтан мессежээр илгээсэн линкээр нэвтэрсэн бөгөөд 3 ажилтан давхардаагүй тоогоор мэдээллээ оруулсан байна.

11.Харилцаа холбооны зохицуулах хороо, Монгол шуудан ХК-ын хүсэлтээр 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулсан. Нийт 58 албан хаагчид сургалтад хамрагдсан.

12."Монголын хөрөнгийн бирж" ХК-н албан хаагчдад 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Мэдээллийн аюулгүй байдлын сургалт зохион байгуулсан. Нийт 26 албан хаагчид сургалтад хамрагдсан.

13.Сангийн яамны хүсэлтээр 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Мэдээллийн аюулгүй байдлын сургалт зохион байгуулсан. Нийт 54 албан хаагчид сургалтад хамрагдсан.

14.Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Коосэн технологийн коллежийн хүсэлтээр 2025 оны 04 дүгээр сарын 07-ний өдөр 6 цагийн сургалт зохион байгуулсан. Сургалтад Мэдээллийн технологийн 1, 2 дугаар ангийн 70 оюутан, Цахилгааны инженерийн 26, Механик инженерийн 31 оюутан тус тус хамрагдсан.

15.Сэлэнгэ аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг хурдан клубийн сурагчдад 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр сургалт орсон. Сургалтад нийт 7 ахмад, 36 сурагчид хамрагдсан.

16.Говь-Алтай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг хурдан клубийн сурагчдад 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр сургалт орсон. Сургалтад нийт 9 сурагчид хамрагдсан гэжээ.

Зорилт 3-ын арга хэмжээ 3.1-д *"Эх сурвалжуудаас ирсэн мэдээллийг нэгтгэх, тайлан мэдээ боловсруулах үйл ажиллагааг автоматжуулах"*арга хэмжээ тодорхой үр дүнтэй хэрэгжиж байна. Тодруулбал: Нийтийн төвийн дашбоард системүүдийн хөгжүүлэлт байнга хийгдэж, 113 тусгай дугаарт ирсэн дуудлага, С2 ботнет буюу алсаас удирдлагатай хортой код программ болон антивируст танигдсан дотоод вирусийн халдвар зэрэг системүүдээр Монгол Улсад бүртгэгдсэн нийт сэжигтэй халдлага, зөрчлийг 4 төрөл, аюул заналын 5 зэрэглэлээр өгөгдсөн хугацаанд гарах тайланг автоматжуулсан. Мөн КАБЗАА-ны даргын 2025 оны А/09 дүгээр тушаалаар байгуулагдсан "Монгол Улсад илэрч буй зарим төрлийн хортой программ хангамжийг хэрэглэгчдийн оролцоогүйгээр алсаас илрүүлэн устгах техникийн боломж шийдлийг боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран туршилт хийх болон хууль эрх зүйн орчны дүгнэлт, зөвлөмж боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд хийгдсэн

туршилтын тайлан болон эрхзүйн үндэслэлийг боловсруулж КАБЗАА-нд хүргүүлсэн гэжээ.

Зорилт 4-ийн арга хэмжээ 4.8-д "Нийтийн төвийн хэмжээнд мэдээлэл солилцох, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан Монгол улсад байршилтай мэдээллийн сувгийг ашиглалтад оруулах, нэвтрүүлэх" төлөвлөгөөний биелэлт Төвийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс Mattermost чат системийг судалж, мэдээллийн сувгийн серверийг Дата төв дээр байршуулан тохиргоог хийж, дотооддоо амжилттай нэвтрүүлсэн гэжээ.

Энэ мэтчилэн "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газар нь Монгол улсын засгийн газрын 2023 оны 8-р сарын 30-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яамны дэргэд байгуулагдсан цагаас хойш тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлж, үйл ажиллагаа нь жигдэрсэн байдалтай байна. Гэсэн хэдий ч уг төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтээс хангалтгүй биелэлттэй хэд хэдэн арга хэмжээ байгаа бөгөөд эдгээр арга хэмжээг 2025 оныг дуусах хугацаанд эрчимжүүлэх шаардлагатай болохыг онцолж байна. Онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай арга хэмжээг дор дурдав. Үүнд:

- ***Арга хэмжээ 4.1***: "Dark Web орчинд кибер аюул заналын судалгаа хийх" арга хэмжээний биелэлтийн явц тодорхойгүй буюу "Тайлант хугацаанд Dark Web" орчинд алдагдсан, худалдаалагдаж буй мэдээллүүдийг илрүүлэх, цуглуулах, шинжлэн дүгнэх зорилгоор Darknet (Tor сүлжээ) дэх 30 гаруй marketplace, forum, leak сайтуудыг шалган судалгааны орчин Tor Browser, VM дээр өгөгдөл хамгаалалтын өндөр түвшнийг ханган ажиллаж 400 мянга гаруй хэрэглэгчийн мэдээллийг илрүүлж холбогдох байгууллагад мэдэгдэж, хариу үзүүлэх арга хэмжээг авч ажилласан" гэж тайлагнасан боловч, ямар судалгааг ямар бүрэлдэхүүнээр хэзээ гүйцэтгэж, ямар үр дүнд хэрхэн хүрсэн, ямар байгууллагад мэдээлэл илгээсэн талаарх биелэлт бичигдээгүй байна.
- ***Арга хэмжээ 4.4:*** "Судалгааны журам боловсруулж, батлуулах" арга хэмжээний биелэлтийг "Судалгааны журмын төслийг боловсруулж удирдлагаас санал авч байна" гэжээ.
- ***Арга хэмжээ 5.2:*** "Сар тутмын цахим товхимол гаргах" төлөвлөгөөний биелэлтийг "Тус төвөөс гаргаж буй цахим товхимол сэтгүүл нь кибер халдлага, зөрчлийн тойм мэдээ, судалгаа, зөвлөмж, танин мэдэхүй, ярилцлага, миний нэг өдөр, үйл явдлын тойм гэсэн тогтмол агуулгын хүрээнд нийт 26-30 нүүртэй байхаар төлөвлөгдсөн. Цахим товхимлын нэр, эх бэлтгэлийн ажил агуулгын төслийг боловсруулан удирдлагаар хянуулж байна" гэжээ.
- ***Арга хэмжээ 6.2:*** "Төвийн үйл ажиллагаанд Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны MNS ISO/IEC 27001:2023 стандартыг нэвтрүүлэх" ажлын явцыг "Төвийн үйл ажиллагаанд MNS ISO/IEC 27001:2023 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд захирлын А/04 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулж, 4, 5 дугаар бүлгийг боловсруулан ажиллаж байна" гэжээ.

Мөн тайлагналт шалгуур үзүүлэлтийн дагуу гараагүй хэд хэдэн арга хэмжээ байна. Тодруулбал:

- ***Арга хэмжээ 3.1:*** Эх сурвалжуудаас ирсэн мэдээллийг нэгтгэх, тайлан мэдээ боловсруулах үйл ажиллагааг автоматжуулах арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг систем, тоогоор илэрхийлэхээр төлөвлөсөн боловч шалгуур үзүүлэлтийн дагуу системүүдийг тоогоор илэрхийлээгүй байна.
- ***Арга хэмжээ 6.1:*** Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайланг хүлээн авч зөвлөмж, шаардлага хүргүүлэх арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хамрагдсан байгууллагын хувиар тооцохоор төлөвлөсөн боловч хувиар илэрхийлсэн тоон тайлан бичээгүй байна.

▪ ***Арга хэмжээ 7.7:***. Цахим хуудасны аюулгүй байдлын талаарх 10 лекцээс бүрдсэн хичээлийг нийтийн төвийн мэргэжилтнүүдэд орох арга хэмжээний биелэлтийг мөн адил зохион байгуулсан сургалтын тоогоор илэрхийлэх байсан атал 2 ажилтныг шалгаруулсан гэж 1 сургалт зохион байгуулсан мэтээр тайлагнажээ.

Мөн төлөвлөгөөний хугацааг 1-4 дүгээр улиралд гэж хэт ерөнхий бичсэн, арга хэмжээний гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийг оновчтой бичээгүйгээс тайлангийн үнэлгээнд нөлөөлсөн болно. Түүнчлэн ихэнх арга хэмжээний биелэлтийг ирүүлэхдээ хэзээ, ямар баримт бичгээр ямар ажиллагаанууд явагдаж байгаа нь тодорхойгүй, төлөвлөгөө бүрийн суурь түвшин, зорилтот түвшинд тавьсан тооны агуулгад нийцээгүй, шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй, тайланд хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн хувийг тавиагүй гэх мэт асуудлууд байлаа.

Иймд "Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв" УТҮГ-ын тайлантай холбоотойгоор дараах дүгнэлтийг гаргаж байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

"Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв" УТҮГ-ын төлөвлөгөөний хугацааг хэт ерөнхий тавьснаас үүдэлтэй нийт ажлын биелэлт эхний хагас жилийн байдлаар ямар хувьтай хийж гүйцэтгэсэн нь тодорхойгүй байлаа.

Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 1-д:

"шалгуур үзүүлэлт" гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг;

"суурь түвшин" гэж үйл ажиллагаа болон бодлогын баримт бичиг, хэрэгжиж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;

"зорилтот түвшин" гэж тухайн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг ойлгоно гэж заасан.

Тус газрын хувьд шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй, зарим арга хэмжээний хэрэгжилт хэт товч, зарим арга хэмжээний хэрэгжилт хэт дэлгэрэнгүй буюу 2000 тэмдэгтээс хэтэрсэн, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх эрэг үр дүнг тодорхой дурдаагүй, тайланд гүйцэтгэлийн хувийг тавиагүй гэх мэт асуудлуудыг арилгаж, 2025 оны эцсийн тайланд зөвтгөн ирүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Түүнчлэн төлөвлөлтийн хувьд чухал томоохон арга хэмжээнүүдэд ач холбогдол өгч ажиллах нь зүйтэй байна. Тодруулбал "Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв" УТҮГ-ын 2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлт 80-аас дээш хувьтай хэрэгжиж байгаа боловч, тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанаас гадна яамны бодлого хэрэгжүүлэх хүрээнд нэн чухал ажлуудыг оновчтой төлөвлөх шаардлагатай байна.

Иймээс цаашид төлөвлөгөө, тайлан болон арга хэмжээг идэвхжүүлж ажиллахтай холбоотой дараах зөвлөмжийг өгч байна.

ДӨРӨВ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

1. Тайлангийн чанар, нотолгоог сайжруулах. Арга хэмжээ бүрийн тайлбар, шалтгаан, үр нөлөөг баримтаар баталгаажуулан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хялбар, нэгдмэл бүтэцтэй тайлагнах.

2. Шалгуур үзүүлэлтүүдийг арга зүйд нийцүүлэн тодорхойлох. Суурь болон зорилтот түвшнийг үр дүнгийн хувьд бодитой, хэмжигдэхүйц, тайлбар бүхий байдлаар төлөвлөх.

3. Төлөвлөгөөний хугацааг бодитой төлөвлөх. Хүрэх боломжит зорилтуудыг тусгаж, явцыг шалгуур үзүүлэлтийн тусламжтай тайлагнаж болохоор тусгаж хэвших.

4. Арга хэмжээг дэд зорилт болгон задалж төлөвлөх. Үндсэн чиг үүргийн хүрээнд хийж буй томоохон чиг үүргүүдийн хүрээнд нэг арга хэмжээг дотор нь задалж дэд түвшинд төлөвлөх, тус бүрийн гүйцэтгэлийг үнэлж нэгдсэн үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх.

5. 2026 онд шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг үр дүнд чиглэсэн байдлаар төлөвлөх. Малгай зорилтын хүрээнд хэд хэдэн арга хэмжээ болгож хуваахдаа агуулгаар нь нэгтгэх.

6. Төсвөөс шалтгаалах ажлын биелэлтийг бодит, дүн шинжилгээтэй, тооцоо судалгаанд үндэслэсэн баримтад тулгуурлан гаргаж хэвших;

7. 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, зөв бичгийн алдаагүй, үг үсгийн товчлол хэрэглэхгүй, агуулгын хувьд тодорхой, ойлгомжтой, зорьсон үр дүндээ хүрсэн эсэх талаар тайлагнаж хэвших;

9. Төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ахиулахтай холбоотой нэгжийн удирдлагууд хяналт тавьж ажиллах;

10. Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дотооддоо хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмжийн хамт яаманд ирүүлж байх.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор батлсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх үүрэгтэй танилцан хамтран ажиллахыг цаашид анхаарна уу.

Жич: Дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрхэн ахиулах болон тайлагнах, ирэх онд хэрхэн зөв төлөвлөх талаар талаар яамны Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас тухай бүр зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.

-oOo-